



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

“Гэр даатгал” ХХК-д даатгалын
хэлбэрийн зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6 дугаар зүйлийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-д барилга угсралтын ердийн даатгалын хэлбэрийн зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, “Гэр даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1-д заасан даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000614
Хүнд
00010